

ажиллаж байгаа ба рашааных нь бүрэлдэхүүнд калий, натрий, кальций, магний, төмөр, азот, хүхэр, устөрөгч, хүчилтөрөгч болон маш ховор тохиолддог уран, радий, родон, литий, бром, ванадий зэрэг чухал элементүүд элбэг байдаг.

Мөн монгол нутагт малыг бэлчээрийн аргаар өсгөж мах, сүү, арьс шир, ноос ноолуурыг боловсруулан экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой бөгөөд одоо өвс ургамлынхаа дөнгөж 70%-ийг ашиглаж /хонинд шилжүүлснээр/ 56,3 сая мал адгуулж байгаа юм. Монгол нь эх газрын эрс тэс уур амьсгалтай учир өвс ургамал нь улирлаар солигдон байнга шинэчлэгддэгээс элдэв хорт нян үржихгүй, сайн чанарын тэжээл болдог онцлогтой. Энэ нь мал аж ахуйн экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг олгодог.

4. Зүүн Хойд Азийн чөлөөт нээлттэй бүсийг монголын зүүн талд байгуулбал Монгол ба Зүүн Хойт Азийн орнуудын хамтын ажиллагаанд бүр ч сайн нөхцөл бүрдэх боломжтой болно. Эндээс төмөр замаар ачаа бараа тээж, БНХАУ-ын хойд районоор дайрч, усан замтай холбох бололцоотой ба тэгвэл Оросын алс дорнод, Япон, БНСУ, БНХАУ-ын хойд район ба Монголын зүүн районыг хамарсан худалдаа эдийн засгийн нээлттэй бүс буй болгох төсөл ч ойрын үед хэрэгжиж болох юм.

Энэ бол Зүүн Хойт Азийн бүс нутгийн хүрээн дэх зөвхөн Монголд байгаа худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны нөхцөл боломж, нөөц бололцоог харуулах үзүүлэлтүүд юм. Одоо бид энэхүү нөөц бололцоог зохистой ашиглахын тулд эдийн засгийн бүтэц, дэд бүтцийг эрчимтэй хөгжүүлэхэд ШУТ-ийн дэвшил, эдийн засгийн гадаад бодлогыг чиглүүлэх зорилт тавин ажиллаж байна. Энэ зорилтыг амжилтай хэрэгжүүлэхэд Азийн орнууд тал бүрийн тусламж үзүүлж байгаа юм. Энэ мэтээр бусад орнуудад асар их нөөц, түүнийг ашиглах арвин их бололцоо байгаа нь тодорхой.

Луу хаашаа тэлэх вэ?

О.Ангараг

Хэдэн мянган жилийн түүхтэй “Торгон зам” Европын эдийн засгийг Хятадын эдийн засагтай холбож ирсэн гол худалдааны зам байсныг бүгд мэднэ. Дэлхий дахинаа чухаг хэрэгцээтэй цай, торго, шаазан зэрэг бүтээгдэхүүнийг олон зууны турш Хятадаас газрын болон усан замаар зөөж ирсэн

түүхтэй бөгөөд Европт аж үйлдвэржүүлэлтийн хувьсгал эхэлтэл Хятадын эдийн засаг дэлхийн хамгийн том эдийг засаг байжээ. Харин тэр үед улс орны хүчин чадлыг тодорхойлогч үзүүлэлт нь худалдаа арилжаа бус цэргийн хүчин чадал, түүний дотор тэнгисийн флот байв. Хятадууд дэлхий дахинаа олон төрлийн технологийг нэвтрүүлсэн ард түмэн боловч аж үйлдвэрийн хувьсгалын гол хөдөлгөгч хүч болсон төмөрлөгийн үйлдвэрлэл, түүнтэй холбогдсон технологийн хувьсгалд хамрагдан орж чадаагүй нь Европын колонилогчдын идэш болон хувирах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Энэ мянган жилд Хятад улс нэгдмэл гүрэн байсан түүх төдийлөн урт бус бөгөөд бүх Хятадыг нэгтгэн захирсан их гүрнийг умар зүгийн нүүдэлчид хан үндэстнээс дутуугүй байгуулж иржээ. /Хятадын нутаг дээр төр улс буй болсноос хойш 764 жил хан үндэстний улс бүх хятадыг нэгтгэн үхирч, 510 жил умардын нүүдэлчид нэгтгэн захирч байжээ. Тоба Вей, Ляо, Зүрчидийн Алтан улс, Юань гүрэн, Манж дайчин гүрэн зэрэг нүүдэлчдийн улсууд Хятадын нутаг дээр засаг захиргаагаа тогтоож, зарим нь Хятад үндэстнийг илтээр ялгаварлан гадуурхсан бодлогыг төрийн бодлогын хэмжээнд явуулж ирсэн байна. Хятадуудын өөрсдийнх нь хочлон нэрлэдгээр “Умардын бүдүүлгүүдийн” ноёрхол хятадуудын дургүйцлийг хүргэж байсан авч олон зуун жилийн дайн самууныг туулан өнгөрсөн ард түмэн хэн гээч нь тэднийг захирч байгааг төдийлөн сонирхдоггүй байсан биз ээ. Нөгөө нүүдэлчид нь ч /Монголчуудаас бусад/ аажмаар Хятадын соёлд уусан, Хятадчилагдаж, сүүлдээ Хятадаасаа ялгагдахын аргагүй хаадууд болж хувирдаг байж. Олон зуун жилийн дараа нүүдэлчдийн эзэрхлийг нураан Синхайн хувьсгалын үр дүнд Хятадын Хан үндэстний төрийг сэргээсэн Хятад орон иргэний дайнд нэрвэгдэж, Японы түрэмгийлэлд өтөн дэлхийн хоёрдугаар дайныг дуустал бүрэн гүйцэд сэргэн босч чадаагүй билээ.

Хятад нэгдсэн тохиолдолд гардаг хэд хэдэн үйл явц нүүдэлчдийн их гүрний засаг захиргааны дор ч өрнөж байв. Юуны өмнө Хятадын дотоодын самууныг зогсоож /цус урсгаж байгаад ч гэсэн/, дэг журам тогтоосноор эдийн засаг сэргэж ирэх хандлага зонхилдог байна. Дотооддоо хэд хэдэн улс болсон Хятадууд хилийн боомтоос чанагш худалдаа хийж чаддаггүй байсан бол нэгэн дээвэр дор нэгтгэн захирснаар Умард-өрнөдийн худалдаа сэргэж ирдэг байв. Мөн дайн

самуунгүйн буянаар хүн ам эрс өсч ирдэг ажээ. Зөвхөн Манж Дайчин гүрний үед гэхэд л Хятадын хүн ам даруй хоёр дахин өссөнийг зарим судалгаа харуулдаг. Чоу /МЭӨ 1027-770/ улсын үед Хятадын хүн ам 14 сая байсан бол Хан /МЭӨ 206-МЭ220/ улсын үед 60 сая болжээ. Манж Дайчин гүрний үед 1762 оны хүн амын тооллогоор Хятадын хүн ам 200 сая байсан бол 1834 оны тооллогоор 400 сая болсон байна. Хүн амын эрс өсөлтөөс үүдэн газрын өлсгөлөн гэдэг аюул Хятадыг бүх түүхийнх нь турш мөшгиж ирсэн бөгөөд хятад иргэд хилийн дээснээс гадна суурьших эдийн засгийн шаардлага тийнхүү үүсэн гарсан байна.

Нэгдмэл Хятад улс /Хан үндэстний ноёрхол дор ч бай, нүүдэлчдийн ноёрхол дор ч бай/ эзэрхэн түрэмгийлэх бодлого явуулж ирсэн түүхтэй. Цин /МЭӨ 221-206/, Хан /МЭӨ 206-МЭ. 220/, Тан /618-907/, Зүрчидийн Алтан Улс /1126 1215/, Юань /1275-1368/, Мин /1368-1644/, Манж Дайчин гүрний /1644-1912/ үед Хятадын хил байнга өргөжин тэлж байжээ. Цин Ши Хуандийн үед түмэн газрын цагаан хэрмийг барьснаар умардын нүүдэлчидтэй хилээ нэг ёсоор тогтоосон мэт боловч хүчирхэгжсэн үедээ Хятадын хаадууд хилээ аль болохоор тэлж, цагаан хэрмийн чанагш ч хяналтаа тогтоож иржээ. Европын тэлэлт шинэ колонитой болох, экспортын шинэ зах зээл нээх, эд баялаг дээрэмдэж, аж үйлдвэржүүлэлтэд ашиглах замаар явж байсан бол Хятадын тэлэлтийн шалтгаан арай өөр байжээ. Төрийн бодлогын хэмжээнд хил залгаа умардын болон өрнөдийн “бүдүүлэг” нарыг харьяандаа оруулан байнга алба бариулж, тэнгэрийн хүүгийн нэр сүрийг өргөх явдал гол байж, доод түвшинд илүүдэл тооны тариачдыг шинэ газар нутагт суурьшуулах явдал болон хувирдаг байв. Цин, Хан, Сүй, Тан улсын үед Хятадын түрэлт голдуу баруун зүгт Торгоны их замыг хяналтдаа авах зорилгоор явагдаж байсан бололтой. Умар зүгт Цагаан хэрмийн чанагш нүүдэлчдийн овог аймгуудыг байнга эзэгнэн захирах нь ашгаасаа алдагдал нь их байсан бололтой. Байнга эзэлэхээсээ хооронд нь хагаралдуулан бутаргаж, хүчийг сулруулах бодлого барьж иржээ. Хятадын хаадын хил хязгаараа тэлэх бодлого өмнө зүгт хойд Вьетнам, дорно зүгт Манжуур, Солонгос, умар зүгт Монгол, баруун өмнө тийш Түвд, баруун зүгт Таримын хөндий рүү чиглэж ирсэн ба голцуу гол мөрний хөндийгөөр газар тариалан эрхлэх иргэдээ суурьшуулах маягаар байнгын хяналтыг тогтоож байжээ. Хятадууд хүчирхэг үедээ шууд

цэрэглэн түрэмгийлдэг боловч хүч нь буурсан үедээ хүнээрээ түрэн, тариачдаа суурьшуулах замаар бага багаар бусад улсын газрыг хятадчилж авдаг. Хятадын тэлэлтийг зогсоож байсан цөөхөн хүчин зүйлс нь байгалийн саад, адил буюу илүү нягтшилтай хүн амтай нутаг, цэргийн хүч гурав байжээ. Манж Дайчин гүрний үед Хятадын хил хязгаар үлэмж тэлж. Монгол, Солонгос, Түвдийг, Амар мөрний сав газрыг хяналтдаа оруулж авчээ. Энэ үеэс эхлэн Хятадад хан, монгол, манж, түвэд, уйгар таван үндэстнийг нэгтгэсэн Хятад улсын тухай үзэл санаа газар авсан байна. Иймээс ч Respublica гэсэн латин нэрийг хөврүүлэхдөө Бүгд Найрамдах Улс хэмээн хөврүүлжээ.

Чан Кайшигийн Хятад Манж Дайчин гүрний хилийг эргүүлэн сэргээх бодлогыг ягштал баримталж, үндсэндээ нөлөөнөөс нь гарчихаад байсан Түвд, Шинжааныг эргүүлэн авсан боловч ЗХУ-ын шууд нөлөөнд байсан Ар Монголыг эргүүлэн авах хүчин мөхөстсөн билээ. Мао Цэдүнгийн удирдлагын дор Хятадын иргэний дайнд ялсан ХКН ч манжийн бүрэлдэхүүнд байсан бусад хязгаараа алдахгүйг чармайж, тусгаар тогтнолоо зарлачихсан байсан Дотоод Монголын БНУ-г нэгтгэн, Түвдэд цэрэглэн орсон юм.


Коммунист Хятад улсын хөгжилд Их үсрэлт, Соёлын хувьсгал гээд багагүй завхрал гарч байсан хэдий ч үндсэнд нь Хятад орныг аж үйлдвэржүүлэх бааз суурийг хатуу гарын дор тавьж авсан байна. Дэн Сяопин Хятадын удирдлагад гарч ирсэнээс хойш “Хятадын онцлогтой социализмын” гол онцлог нь прагматизм болж, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйд коммунистуудыг тарааж, зах зээлийн үндсийг нэвтрүүлэх бодлого явуулж эхэлсэн билээ. Дэн Сяопин “Дөрвөн шинэчлэлийн бодлого явуулж эхэлсэнээс хойш арав гаруй жил өнгөрсөн боловч Хятадын эдийн засгийн хөгжлийн хурдац дэлхийд толгой цохих хэмжээнд хүрсэн байна. Өнөөдрийн Хятад үнэн хэрэгтээ эдийн засгийн нийт хэмжээгээр АНУ, Японы дараа орох төлөвтэй хөгжиж явна.

Улс орны эдийн засгийг хэмжихдээ тухайн улсын нэг хүн ногдох орлогоор нь буюу дотоодын нийт бүтээгдэхүүнийг Америк долларт албан ханшаар нь шилжүүлж хэмжиж ирсэн уламжлалтай. Энэ аргачлалын нэг муу тал нь тухайн улсын валют доллартай харьцуулахад ханш муутай эдийн засаг тэр чигтээ “агшиж” үнэн байдлаас төсөөрсөн дүр зураг гардаг. 1978-1992 оны хооронд Хятадын юань-долларын ханш 1.7 гоос 5.5 хүрчээ. Гэхдээ уламжлалт аргаар ДНБ-ийг тооцвол

БНХАУ дэлхийн 10 дахь эдийн засаг бөгөөд иргэд нь хорвоогийн хамгийн ядуу иргэдийн нэг болно.

1993 онд Олон улсын Валютын Сан /ОУВС/ тухайн улсын валют өөрийн улсад үйлдвэрлэгдсэн бараа үйлчилгээг худалдан авах чадварыг тооцож түүнээс нь тухайн орны үндэсний үйлдвэрлэлийг тооцон гаргажээ. Худалдан авах чадвар /ХАЧ/-ын аргаар тооцоод үзэхэд 1992 онд БНХАУ 1.7 триллион долларын бараа үйлчилгээ үйлдвэрлэсэн гэж тооцогдсон нь өмнөх 400 миллиард гэсэн тооноос үлэмжхэн давсан бөгөөд 1992 онд нэг хүнд ноогдох үндэсний орлого нь 370 ам. доллар ч биш, 1600 болж гарчээ. ОУВС тооцоогоо хийхдээ энэ салбартаа дэлхийд толгой цохидог Пенсилваны Их Сургуулийн профессорууд Роберт Саммерс, Алан Хестон нарын боловсруулсан НҮБ-ын харьцуулалтын хөтөлбөрөөс гаргасан үнийн тоо баримтыг ашигласан байна. Саммерс, Хестон нарын боловсруулсан тоо баримт, анализыг ашиглаад бодоход Хятадын нэг хүнд ногдох Үндэсний орлогыг /НХНҮО/ 2598 доллар буюу ДНБ нь 1990 оны 1990 оны үнээр 2.9 триллион ам доллар гэсэн тооцоонд хүрчээ. Энэ тоог арай их байна гэж үзээд ОУВС АНУ-ын тооцооны албаны Олон улсын судалгааны төвийн тоо баримтыг ашигласан байна. Гэтэл зарим эдийн засагчдын тооцоогоор Хятадын бодит НХНҮО 4000 ам доллар хүрч байгаа ажээ /Чингэснээр Хятадын эдийн засаг Японыхоос ч том болох байна/.

Хэрэв Хятадын НХНҮО нь 1600 доллар юм бол эдийн засаг нь 1,2 миллиард хүнийг 1600 доллартаа үржээд 1.7 триллион болох бөгөөд Японы 2.4, АНУ-ын 5.6 триллионоос арай бага болох нь ээ. Хятадын хөгжлийн өсөлтийн боломжийг тооцоолбол бүр сонин дүр зураг гарна. Хятадын НХНҮО Өмнөд Солонгосын 7561 долларын хэмжээнд хүрвэл эдийн засаг нь 9 триллион долларын хэмжээнд хүрнэ. Хэрэв Тайваны Хятадуудын 10000 долларын хэмжээнд хүрвэл эдийн засгийн хэмжээ 12 триллион болж, АНУ-ын одоогийн эдийн засгийн хэмжээнээс хоёр дахин том болох юм. Малайзын стратегийн болон улсын судалгааны хүрээлэнгийн захирал Нуурдин Сопие-гийн үзсэнээр 2020 он гэхэд АНУ-ын ҮНБ ийг 100% гэж үзвэл БНХАУ-ынх 140% болох ажээ.




Зураг 1: 1992 онд дэлхийн тэргүүлэх 10 эдийн засаг

1978 оны 12 дугаар сард хуралдсан ХКН-ын ТХ-ны 11 дүгээр бага хурлаар эдийн засгийн шинэтгэл явуулахаар шийдсэнээс хойш БНХАУ-ын эдийн засаг бараг жилийн 11-13 хувийн хурдацтайгаар өсч, сүүлийн жилүүдэд “хэт халсан” эдийн засгаа хөргөх арга хэмжээ Бээжин авахад хүрсэн байна. Энэ хурдцаар өсөлт яваад байвал 2002 онд эдийн засаг 1978 оныхтой харьцуулахад 8 дахин том болж, хурдац далайцаараа Япон Солонгосын эдийн засгийн “гайхамшигаас илүү давсан “гайхамшиг” шинээр гарч ирэх нь ээ.

Гэхдээ ард түмний амьдралын түвшинг эдийн засгийн хэмжээтэй хутгаж болохгүй. Хятадын хүн болгон хувийн машинтай болбол лавтайяа экологийн сүйрэл гарч дэлхийг тойрсон озоны давхарга улам зузаарах байлгүй гэж олон эрдэмтэд хошигнон жишээлж ирсэн.

Хятадын эдийн засаг хөгжих тусам өрнөдийн томоохон корпорацууд хөрөнгө оруулах сонирхолтой болж байна. AT&T, Motorola холбоо харилцааны контрактууд дээр уралцаж, шинээр баригдаж буй нисэх буудлуудын барилгын контракт олж авахаар хойно хойноосоо гүйлдэж гарлаа. 2000 он гэхэд Хятадын 500 гаруй нисэх буудал шинэчлэгдэх ба хэдэн миллиардаар ярих нисэх онгоцны парк шаардагдах төлөвтэй ажээ. 80-аад оны эцсээр анхны highway-гээ барьж суусан Хятадууд өнөөдөр 35000 км уртыг тавихаар төлөвлөөд ажиллаж байна. Бээжингээс Шэньжэн ороход 2400 км урт highway барьжээ. Кока Кола, Проктер энд Гэмбл, Кодак, Женерал Моторз гээд бүгд Хятадын зах зээл рүү хошуурцгаав.



Зураг 2: 2020 онд дэлхийн тэргүүлэх 10 эдийн засаг

Дэлхий дахинаар өрнөсөн хэрэглээний хувьсгал Хятадыг тойрсонгүй. Мао Цэдүнгийн үеийн ногоон хувцастай баатрууд моодноос гарч өрнөдийн амьдралын хэв загвар хятад хүний мөрөөдөл болж эхлээд байна. Зарим үед Хятадын удирдлагад суугаа коммунистууд “бид мэдээгүй юм шиг л байя, та нар хөрөнгөтөн нийгмээ байгуулж л бай” гэсэн байр суурьтай юм шиг харагдахаар болов. Тяньаньмэний талбайд болсон эсэргүүцлийн хөдөлгөөн цаашдаа коммунист үзэл сурталд өөрчлөлт оруулах шаардлага байгааг харуулав. 90-ээд оны эхээр өрнөсөн дэлхийн коммунист хөдөлгөөний хямрал ХКН-д мөн нөлөөлж, ХКН-ын удирдлага үзэл суртлын шинэ хайгуулд мордон Гүнзийн сургаалыг хүртэл нэг намын ноёрхолтой уялдах үзэл суртлын зэмсэг болгохоор оролдож байна. Хятадын шинэ үзэл суртал юу байх вэ? Ямар изм-ийг олж тавихыг үзэл сурталчид дороо бодоод олчихно, ямар ч атугай прагматик үзэл, коммунист үзэл хоёрын сонин хоршил гарч ирэх бололтой. Үзэл суртлын шинэ аян дайнд Хятадын үндэсний үзэл сэргэн ирэх нь тодорхой. Олон зуун жил гадаадынхны нүдний үзүүр болж, дарлагдаж явсан хятадууд өнөөдөр олон улсын хамтын нийгэмлэгийн бүрэн эрхтэй гишүүнээр тогтохгүй, дэлхийн бодлогод нөлөө үзүүлэх гүрэн болсноо нийтээр ухамсарлахын хэмжээгээр Хятадын үндэсний үзэл улам газар авч байна. Үндэсэрхэг үзэлтэй Хятад орон Коммунист Хятадаасаа илүү эзэрхүү, гадагшаа тэлэх хандлагатай байх болно гэж эрдэмтэд үзэж байна.

Энэ бүх үйл явцын нэгэн сонин үр дагавар нь хэдэн мянган жилийн турш газар тариалангийн илүүдэл хүчээ хилийн чанд дахь үржил шимтэй газар луу шахаж өргөжиж ирсэн Хятадын тэлэлт цоо шинэ өнгө аястай болж буй явдал юм. Технологийн хөгжлийн үр дүнд илүүдэл хүн ам заавал газар тариалан даган тархах шаардлагагүй болж, эдийн засгийн шинэ төсөл, томоохон бүтээн байгууллагыг даган урсаж байх боломжтой болжээ. Хэрэв урд нь Хятад иргэдийн тэлэлт байгалийн нөхцөлийг дагаж олон газар тариалангийн бүсийг дагадаг байсан бол /Өвөр Монгол, Шинжааны жишээг үзэхэд/ одоо цаг уурын нөхцөл саад бэрхшээл болохоо больсон байна. Хятадын эдийн засаг томрох тусам том төсөлд зарах хөрөнгийн боломж үүсч, томоохон бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэн түүнийг дагалдан үлэмж тооны хятад иргэд ажиллах хүч маягаар тухайн бүс нутагт суурьших явц харагдаж эхлэж байна. Таримын хөндийн нефть олборлох төсөл, Түвдийг хөгжүүлэх программ гээд энэ үйл явц Хятадын дотоодод эрчимжиж, олон зууны турш байгаль цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан очиж чаддаггүй байсан районуудад өнөөдөр хятад иргэд олноор суурьшиж эхэллээ.

Хятадын тэлэлт урьдын адил хэлбэрээр юм уу хүчирхэгжсэн Хятад ийш тийшээ цэрэглэн орж түйвээнэ гэж үзэх нь өрөөсгөл болов уу. Олон улсын харилцаа хэв шинжээ олсон өнөөгийн нөхцөлд аливаа нэгэн улсын эсрэг цэргийн түрэмгийлэл үйлдэх нь тийм ч амар хэрэг биш. Хятадын экспанси цаашдаа хүн ам, газар нутгийн хэлбэрээр бус, эдийн засаг-хүн амын тэлэлтийн хэлбэрээр явагдахын нэгэн шалтгаан үүнд оршиж байгаа юм. Цаашдаа Хятадын экспанси газар нутгийн илүүдэл бус, эдийн засгийн буурай хөгжилтэй бүс нутаг, хөрөнгийн дутагдалтай газрууд руу чиглэх хандлага үүнээс харагдаж байна. Зүүн Өмнөд Азид нүүсэн хятадууд тус улсын эдийн засгийн өндөрлөгт өөрийн томоохон байр суурийг эзлэн авсан үйл ирэх зуунд давтагдахыг үгүйсгэх газаргүй юм. Хил залгаа улс орнуудын хэмжээнд Хятадын тэлэлтийн нөлөө Монгол, Бирм, Казахстан, Лаос зэрэг орнуудад юуны өмнө мэдэгдэх болов уу.

Олон зуун жилийн турш барьж ирсэн хүн амыг хязгаарлах бодлогоо 1955 оноос төрийн бодлогын хэмжээнд зарласан хятадын гэр бүлд өөрчлөлт гарчээ. Ганцхан хүүхэдтэй байх эрхтэй айл ганц хүүхдээ эрэгтэй байлгихыг хүсэх нь зүй. Чингээд эрэгтэй хүн амын тоо нийт хүн амын хэмжээнд

нэмэгдэж эхэлсэн байна. Хятадын хүн амын түрэлт эрэгтэйчүүдээр дамжин явагдаж, хятад эрчүүл голлон харийн эхнэр авахаас бус хятад хүүхнүүд гадаадын хүнтэй суух нь ховор ажээ. Эцгийн эрхт ёс ноёрхсон өнөөгийн нийгэмд ийм гэр бүлийн үр хүүхдүүд эцгийн соёл, өв уламжлалыг авах нь гарцаагүй хэрэг. Ийнхүү хуацяо нарын үр хүүхдүүд хятадчилагдаж, тухайн улс орны үндэсний соёлыг авахаасаа хятад соёл иргэншлээ дагаж, хятад хүн амын давхаргыг нэмэгдүүлж ирсэн байна. Хятад гэр бүлийн хоёрдахь хүүхэд эх орондоо нийгмийн бүрэн эрх эдэлж чаддаггүйгээс нутгаасаа халин зайлах эрмэлзлэл бүхий, яахаас ч буцахгүй авантюрист үзэлтэй хүн амын давхрага үүссэн байна. Эх орондоо илүүдэл ийм хүч Хятадын түрэлтийн эхний давалгаанд орж ирдэг ажээ. Ийм хүмүүс ямар ч ажил хийхээс татгалзахгүй, ямар ч хөлс авахаас дүргүйцэхгүй тул хямд төсөр ажлын хүч болон хилийн чанадад түгж, аажмаар нутгийн хүн амтай уусан хуацяо нарын эхний давхаргыг бүрдүүлж өгдөг. Зарим мэдээгээр Хятадын дотоодод урсаж явдаг ийм ажилгүйчүүдийн тоо 200 сая хүрдэг ажээ.

Азийн эдийн засгийн хөгжилд тэргүүлэх гавьяа байгуулсан “Азийн 4 барын” Өмнөд Солонгосоос бусад улсын эдийн засагт Хятад гаралтай хүн ам буюу хуацяо нар давамгайлах талдаа билээ. БНХАУ-ын нутаг дэвсгэрээс гадна оршин суугаа хятад үндэстэнгүүд 50 сая гаруй ажээ. БНХАУ-д цутган орж байгаа гадаадын хөрөнгө оруулалтын 85 хувь нь Гонконг, Тайван, Сингапур, Японоос орж байна. Сингапур, Малайз, Тайланд, Индонези, Филиппиний хувийн хэвшлийн ихэнх хувийг Хятад гаралтай иргэд гартаа атгаж байна. Өрнөдийн бизнесийн ертөнцөөс гадна хятад хэлээр хоорондоо харилцаж, тэр маягаараа хоорондоо илүү дотно санагдах Хятадын бизнесийн ертөнц үндсэндээ үүсч буй болчихоод байна. Улс төрчдийн нэрлэдэгээр “Их Хятад”-ыг эргүүлэн сэргээх үйл явц эдийн засгийн салбарт мэдэгдэхүйц явагдаж эхэлжээ. 1993 оны 11 дүгээр сард Гонконгд болсон Хятад бизнесменүүдийн дэлхийн II уулзалтыг зохион байгуулахад “Дөрвөн далайгаас ирсэн Хятад бизнесменүүд таван тивд хөгжил цэцэглэлийг авчирна” гэсэн лоозон цууриатуулсан нь нэгийг хэлэх биз ээ. Олон жилийн турш хөрөнгийн гачигдалд байж, баян орнуудын үүдэн дээр тагшаа бариад сууж байсан хятадууд 1993 онд Японы жижиглэн

худалдааны томоохон корпорац Yohan International-ын хяналтын багц хувьцааг худалдаад авчихлаа.

Эдийн засаг нь сэргэхийн хэмжээгээр Хятадын улс үндсээрээ бахархах үзэл газар авчээ. Хятад орон дэлхийд шийдвэрлэх дуу хоолойтой үндэстний нэг гэсэн бодол Хятадуудыг байнга гижигдэж байна. 1996 оны 4 дүгээр сард Францад айлчлан очсон Ли Пэн Францын Ерөнхий сайд төрийн зоогны үгэндээ хүний эрхийн асуудлыг дурдах гэж байгаад дүргүй нь хүрч зоогонд хоёр цаг хожигджээ. Дипломат харилцааны түүхэнд ховорхон тохиолддог энэ демаршт шахагдсан Францчууд Ли Пэний дургүйг хүргэсэн тэр үгийг Ерөнхий сайдынхааүгнээс хасахаас өөр аргагүй болжээ. Хятадууд чингэж францчуудын амыг хамхиж орхилоо. Тайваны ерөнхийлөгч Ли Дэнхуэй тусгаар тогтнолоо зарлана гэж мэдэгдмэгц Хятадын Ардын чөлөөлөх армийн анги нэгтгэлүүд хил дээр нь хээрийн сургууль хийж гарав. Америкууд флотоо Формозын хоолойд татсанаар арай л болчихолгүй энэ хэрэг шувтарсан боловч Америкчуудаас ч айхгүй шүү гэсэн дүр зураг Хятадууд эсгэж чадав. ЗХУ задран бутарснаар байлдааны тэргүүн зэргийн шинэ зэвсэг үлэмж хэмжээгээр Хятадын Ардын Чөлөөлөх армид шилжсээр байгаа нь нууц биш. ХАЧА өнөөдөр зэвсэглэлийн түвшин, бие бүрэлдэхүүний тоо зэргээр дэлхийд толгой цохих армийн нэг болон хувирч байна.

ЗХУ задран бутарсанаас БНХАУ-тай жин, нөлөө, эдийн засгийн болон цэргийн хүчин чадлын хувьд давамгайлах гүрэн хил залгаа үгүй боллоо. Япон, Өмнөд Солонгос, Тайван зэрэг эдийн засгийн хувьд өрсөлдөх чадвар бүхий улс орнууд Хятадыг тойрон байгаа боловч Хятадын эдийн засгийн нөлөө улам өргөжих хандлага давамгайлсан хэвээр байна.

Гэвч өрнөдийн хэрэглээний үзэлд нэвтэрч кока кола ууж, Марлборо татсан залуу үеэ Хэдий болтол Коммунист нам захирч чадах бол гэдэг хариулагдаагүй асуудал зүй ёсоор урган гарч ирнэ. Соёлын хувьсгалын үед хөдөө тосгонд Хөөгдөж, "зүрхээ зүсүүлсэн" залуу үе шувтарч байгааг Тяньамаэний талбай харуулсан. "Ард түмэн гэдэг ухаан суугаагүй хүүхэд, түүнийг төр шавхуурдаж ухааруулдаг" гэсэн Гүнзийн сургаал өнөө үеийг хүлээсэнд удаан барихгүй биз ээ. Аж үйлдвэрт шинэ технологи нэвтрэх тусам ажилгүйдэл нэмэгдэж, хээл хахууль авах явдал газар сайгүй болж, ханшны уналт эдийн засагт муугаар нөлөөлөх боллоо. Эцэс төгсгөлгүй барина гэж

байхгүй тул өнөөдөр Хятадад бараг газар сайгүй өрнөсөн их барилгын ажилд хамрагдсан ажлын хүч аужлын фронт хумигдаад эхлэхлээр эдийн засагт нэмэгдэл дарамт болох нь зайлшгүй.

Ирэх зуунд томоохон их гүрний хэмжээнд гарч боломжийг хангасан Хятад АНУ, Япон, ЕЭЗХН болон АСЕАН-тай жингээрээ тэнцэх томоохон эдийн засаг болж гарч ирэх үйл явц гүнзгийрэх тусам Хятадтай хил залгаа улс орнуудын стратегийн ач холбогдол нэмэгдэх төлөвтэй байна. Хятадтай хил залгаа улсуудын зах зээлийн төлөө тэмцэл улам хүчтэй болж, эдгээр орнуудыг Хятадын эдийн засгийн орбитод оруулчихгүй байх нь эдийн засгийн бусад томоохон төвүүдийн зорилт болон гарч ирэх болно.

Дэн Сяопин нас барсаны дараа коммунист системээ хадгалан барихын тулд Хятадын шинэ удирдлага хатуу бодлого баримталж эхэлж болзошгүй бөгөөд прагматик үзэл ноёрхох болсон эрэг орчмын болон Өмнөд Хятадын нөлөө ихэсч, Гүнзийн сургаалаар дөрөөлсөн шинэ коммунистуудын үзэл сурталд үндсэрхэг үзлийн жин нэмэгдэх бололтой. Эдийн засгийн хувьд Гонконг, Тайвань, Сингапур, Макао, Монгол, Хойд Солонгос мөн түүнчлэн Оросын Алс Дорнод, Зүүн Сибирийг Хятадын нөлөөлөл дэс дараалан оруулах гэсэн оролдлого өргөжиж болзошгүй юм.

Оросын дотоод байдал тогтворгүй хэвээр байгаа нь эдийн засагтаа шууд нөлөөлж, дэлхийн эдийн засагт Орос улсын эзлэх жинг цаашид багасгах хандлага үргэжилж байна. Орос улс ийм байдалтай байгаа нь Монголын хилийг тойрон хүчний вакуум үүсгэх аюултай бөгөөд ийм нөхцөл байдалд орсон буфер улсын хувь заяаг дайны дараах Түвдийн хувь заяа бэлхнээ харуулж байна. Оросын Ерөнхийлөгч Б.Ельцин саяхан Дундад Азийн хэдэн улсынхныгаа дагуулж очоод баахан гэрээ, хэлэлцээр гарын үсэг зурлаа. Орос-Хятадын хил дээрх цэргийн сөргөлдөөнт байдлын үе шувтарч, "хамтран ажиллах" нэртэй шинэ өргийг тавьж эхэллээ. Монголын тухай асуудал Бээжинд яригдсан эсэхийг би бээр мэдэхгүй юм. Харин түүхээсээ үзэхэд "цор цор хийж үймүүлээд байдаг" Монголчуудыг хэрэгтэй үедээ хэлэлцээ ярианд бамбай болгон барьж, хоёр талаас баахан шавхуурдаад эцэст нь найруулсан "эмээ" тулган уулгадаг явдал зөндөө байжээ. Хэрэггүй бол хоюулхнаа тохиролцчихоод Монголчуудад ёсыг бодож, дуулгадаг, заримдаа дуулгахыг ч илүүд тооцдог явдал бишгүй гарсан.

Манай дипломатчид идэвхжихгүй бол төмөр зам Өрөмч, Манжуураар Монголыг тойрч, түүнийг даган бараа эргэлт мөн тойрон урсах төлөв харагдаж эхэллээ. Худалдаа нэртэй их мөрний урсгал Монголын нутгийг тойрч урсах нь дахиад л XXI зуунд газрын мухарт цөлөгдөн, усныхаа шанагыг бариад айлын хаяа царайчилдаг дүр зураг эргээд гарах төлөвтэй ажээ. Оросууд Зүүн Азийн эдийн засгийн интеграцийн үйл явцад шалавхан орох гэж нэгэнт хөдөлсөн галт тэрэгний хойноос санд мэнд харайж явааг бид хараад нэгийг бодох цаг болсон болов уу.

Зүүн Хойд Ази болон Төв, Дундад азид идэвхтэй үүрэг гүйцэтгэж чадах бүс нутгийн интеграц, эвсэл бүлэглэл үүсээгүй байгаа нь Монгол улсын үндэсний аюулгүй байдалд нөлөөлж байна. Зүүн Хойд Азид идэвхтэй эдийн засгийн бүлэглэл үүсэх бололцоо хязгаарлагдмал байгааг хоёр Солонгосын харилцаа, Түмэн голын төслийн хувь заяа зэрэг зүйлс харуулж байна. Гэтэл Зүүн Ази, Зүүн Хойд Азийн хэмжээнд бүс нутгийн эдийн засгийн интеграцчилалын үйл явц зангидах механизмгүйгээр эхэлчихээд байна. Хэдийгээр бүс нутгийг ерөнхийд нь хамарсан Европын хамтын нийгэмлэг маягийн байгууллага байхгүй боловч Зүүн Азийн дотоод худалдаа жилд бараг 8,6 хувиар өсч байна. Эдийн засгийн энэ интеграцийн гол хөдөлгөх хүч нь засгийн газар бус, пүүс, компани зах зээлийн эдийн засаг байлаа. АСЕАН-ны экспортын 50, шинээр аж үйлдвэржсэн орнуудын 41, БНХАУ-ын экспортын 64 хувь тус бүс нутагт ногдож байна.⁷ Газар зүйн хувьд далайгаас таслагдсан, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний нэр төрлөөр хөрш зэргэлдээ хоёр орноосоо давж гавиад байх юмгүй Монгол улсын хувьд эдийн засгийн энэ интеграцийн үйл явцад хамрагдах нь бэрхшээлтэй нь ойлгомжтой. Эдийн засгийн интеграцыг гүнзгийрүүлэх үйл явцыг өөрийн эдийн засгийн бодит бололцоог харгалзан тодорхой цөөн тооны салбаруудад технологийн өндөр түвшинтэй болохыг хичээн, аль болохоор хөрш зэргэлдээ бус орнуудын орлоонд түшиглэн ажиллахыг эрмэлзэх нь зүйтэй биз ээ. Монгол улс цаашдаа өргөн бүс, тивийн чанартай бүлэглэлүүдэд багтан орохыг хичээх, Зүүн хойд Азийн эдийн засгийн интеграцийг гүнзгийрүүлэх, бүлэглэл үүсэхийг бүх бололцоогоор дэмжих ёстой. Мөн Төв, Дундад Азид идэвхтэй бодлого явуулж, харилцаагаа өргөжүүлэх бодлого барих нь зүйтэй.

Коммунист үзэл суртал ноёлох байр сууриа алдсанаас хойш Монголд энгийн ухамсрын түвшинд идэвхтэй нөлөөлж чадах үзэл суртал үгүй болж, үндэсний үзэл болон шашны сэргэн мандалт коммунизмыг орлох гол хүчин зүйлүүд боллоо. Буддийн шашны сэргэн мандалтыг өнөөгийн нөхцөлд зөвөөр ашиглахын тулд шашны дотоодын реформист үзлийг дэмжих, хуучин хэлбэрээр нь сэргээхээс монголжуулж авах, бусад шашны нөлөө хэт ихсэхийг хязгаарлах, ялангуяа хил залгаа улсуудын шашин газар авахаас урдчилан сэргийлэх шаардлагатай. Манай эдийн засаг сүүлийн жилүүдэд сэргэх хандлага үзүүлж байгаа боловч хөл дээрээ зогсох болоогүй гэдэг нь хэн хүнгүй ойлгомжтой.

Хятадын хүчин зүйлийн жин дэлхийн хэмжээнд өсөх тусам хил залгаа улсууд, түүний дунд Орос, Хятадын дунд орших Монгол улсын стратегийн ач холбогдол өсч ирэх ёстой. Эдийн засгийн бусад томоохон төвүүд түүхий эдийн нөөц ихтэй, чухал байрлалтай Монголыг Хятадаас өрсөөд олоод авчихыг бодох нь зүйн хэрэг. Эл байдлыг хуучин ЗХУ-ын үеийнх шиг зээл, тусламжийн ширгэшгүй эх булаг мэтээр ойлгох нь хэтэрхий өрөөсгөл хандлага болно. Монголын эдийн засагт орж ирэх гадаадын хөрөнгө оруулалт ямар ч тохиолдолд, Хятад Оросын эдийн засаг дахь гадаадын хөрөнгө оруулалттай жишихийн аргагүй бага хэмжээтэй байх нь ойлгомжтой бөгөөд ийм үед гадаад гүрний шууд өмөг түшигт багтана гэдэг хир бодит зүйл болохыг Хятад-Америкийн харилцаа бэлхнээ харуулж байна. Хятадад худалдааны нэн тааламжтай нөхцөл олгох асуудлыг АНУ хүний эрхийн асуудлаас салган үзэх хандлагатай байгаа нь ёс суртахууны зарчмаас эдийн засгийн давамгайлах байдалтай байгааг илтгэж байна. Энэ зарчим манай тохиолдол дээр ч хэрэгжихгүй гэх баталгаа үгүй биз ээ.

Монгол улс ардчилсан өөрчлөлт хийж эхэлсэн, эдийн засгийн шинэтгэл харьцангуй амжилттай яваа орны хувьд тодорхой хэмжээнд Өрнөдийн анхаарлын бүст багтан орсон. Цаашид энэ анхаарлыг буруулахгүй байлгаж, Хятадын эдийн засгийн орбитод багтаад орчихгүй байхыг хичээх нь бидний гол зорилго болох биз ээ. Энэ зорилгыг хэрэгжүүлэх нь дан ганц эдийн засгийн бодлого биш бөгөөд улс төр, стратегийн уялдаатай бодлого явуулах шаардлага урган гарч ирж байгаа юм. Монгол улсын гадаад бодлого, эдийн засгийн бодлого нь нээлттэй, тэргүүний шилдэг технологийг түшиглэсэн, цөөн тооны тэргүүлэх эдийн засгийн чиглэлийг сонгон түүгээрээ

дэлхийд өөрийн байр суурьтай байх шаардлагатай болов уу. Өнөөдөр Монгол улсын экспортын гол бүтээгдэхүүн-зэсээ бид боловсруулах бүтэн дамжлагагүй байна. Ноолуурын зах зээл дээр Монголчууд хятадын дараа оррох байр суурь эзэлдэг гэх боловч өнөөг хүртэл бүрэн боловсруулалт хийх технологийн системгүй байгааг бодолцож үзэх хэрэгтэй юм. Ямааныхаа ноолуурыг самнаад угаагаад, топс хийгээд утас ээрээд цамц нэхчихдэг болсон нь сайшаалтай авч, дээд зэргийн даавуу үйлдвэрлэх, ноолууран пальто, ноолууран алчуур хийх технологийн дамжлагатай болж, boutique худалдааны зах зээл дээр хөлөө тавьж үзмээр байна. Монголын нутгаар дамжин өнгөрөх тээврийн асуудлыг хөнгөвчлөх, бараа засгийн чиглэлийг сонгон түүгээрээ

Үзүүлэлтүүд	Монгол	Орос	Хятад
Улс төрийн байгуулал, тогтворжилт	<i>Ардчилсан Харьцангуй боломжийн</i>	<i>Ардчилсан Тодорхой бус</i>	<i>Тоталитар Харьцангуй боломжийн</i>
Эдийн засгийн шинэчлэл	<i>Харьцангуй амжилттай</i>	<i>Төдийлөн амжилттай бус</i>	<i>Нилээд амжилттай</i>
Дэд бүтэц	<i>Хөгжөөгүй</i>	<i>Бага зэрэг хөгжсөн</i>	<i>Харьцангуй хөгжсөн</i>
Хууль зүйн тогтолцоо	<i>Тогтношиж буй</i>	<i>Тогтношиж буй</i>	<i>Тогтсон боловч учир дутагдалтай</i>
Ажиллах хүч	<i>Дутмаг</i>	<i>Хангалттай</i>	<i>Илүүдэлтэй</i>
Нийгмийн хэв журам	<i>Дажгүй</i>	<i>Сайн бус</i>	<i>дажгүй</i>
Бие даасан шүүхийн тогтолцоо	<i>Тогтож буй</i>	<i>Үүсээгүй</i>	<i>Байхгүй</i>
Хөрөнгө оруулалтаас олох ашгийн түвшин	<i>Дунд зэрэг</i>	<i>Өндөр</i>	<i>Өндөр</i>
Ашгаа буцаан гуйвуулах боломж	<i>Хуулийн хувьд боломжтой, бодит механизм үүсээгүй</i>	<i>Асуудалтай</i>	<i>Харьцангуй боломжийн нөхцөлтэй</i>
Зах зээлд хүрэх боломж	<i>Хэцүү</i>	<i>Бэрхшээлтэй боловч боломжтой</i>	<i>Харьцангуй боломжтой</i>
Түүхий эд	<i>Элбэг</i>	<i>Элбэг</i>	<i>Элбэг</i>
Банкны систем	<i>Боловсронгүй бус</i>	<i>Боловсронгүй бус</i>	<i>Хангалттай</i>

эргэлтийг нэмэгдүүлэх талаар ч анхаарууштай. Мэдээллийн сүлжээ, технологиор хоцорсон Алс Дорнод, хойд Хятадын зах зээлтэй хиллэн оршдогийн хувьд эдгээр зах зээлийг үсрээд явчихаас өмнө өөрийн гэсэн байр сууриа үүсгэж авах нь чухал биз ээ.

Монголын зах зээл улс төрийн тогтвортой байдал амлаж байгаагаараа хөрш хоёроосоо илүү боловч үлэмж олон дутагдалтай тал байгааг мартахын аргагүй. Далайгаас таслагдсан, эрэлт хэрэгцээ доогууртай, банкны систем бүрэн сайн хөгжөөгүй, дэд бүтцийн хөгжил хангалтгүй гээд зөндөө олон дутагдал тоочиж болно. Хуулийн бие даасан системийг хөгжүүлэх, гадаадын хөрөнгө оруулагчид ороод ирэхэд шаардлага хангах хууль зүйн системийг үүсгэж чадвал зэргэлдээ хоёр зах зээлээс давуутай хүчин зүйл үүсгэх талтай. Эдийн засгийн шинэчлэлийн бодлогодоо бид хоёр хөршөөсөө давуу технологийг үйлдвэрлэлдээ нэвтрүүлэх, дэд бүтцээ эрчимтэй хөгжүүлэх, чингэснээр Монголыг хөрөнгө оруулалтын нэг сонирхол татсан цэг болгон хувиргах шаардлагатай.

Монгол улсын цаашдын ирээдүйд Хятадын эдийн засгийн өсөлтийн үзүүлэх нөлөөг бид ухаалгаар ашиглаж чадвал бидний цаашдын ирээдүйд нэмэр болох нь дамжиггүй. Луугийн тэлэл үргэлжлэх л болно. Харин бид тэлэлтийг яаж өөртөө хэрэгтэй зүйл болгож авах вэ гэдэг асуудлаар оюун бодлоо уралдуулах ёстой болов уу.

Түүх,
орчин үе

**“Дөчин Түмэн Монгол улс” хэмээх
нэрийдлийн судлал**

/Түрүүч нь 1996 оны 1,2 дугаарт/

Монголжин Алтан-Оргил

Гурав. 1619 оноос өмнөх холбогдол бүхий эл зүйлийн сурвалж бичгүүдэд тэмдэглэсэн дөчин түмнээс үзэхэд:

Өмнө өгүүлснээр Саган сэцэний “Эрдэнийн товч”-д хэлсэн дөчин түмэн Бэтэ улсын дотор умар дахины эртний угсаа, үндэстнийг нэгтгэн байгуулагдсан Хүн хаант улс, Сяньби Шилбэ Хаант улс, Түргүүд Хаант улс, Монгол Хаант улс цөм багтдаг билээ. Мөн эдгээр улс гүрнийг байгуулсан Хүн-Түргүүд-Монгол нь гарал үүсэл, язгуур дээдэс нэгтэй ажээ. Ийнхүү эртний Перс сурвалж бичгүүдэд Түргүүд, Татар,